

ТАНИЛЦУУЛГА

"Ухаалаг засаг-II төсөл"-ийн тухай

1. Төсөл хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага

1.1. Өнөөгийн нөхцөл байдал, цаашдын хандлага

Нэгдсэн Үндэстний Байгууллага /НҮБ/-аас гаргадаг "Иргэдийн цахим оролцооны индекс"-ээр Монгол Улс 2022 оны байдлаар 74 дүгээр байрт, "Дижитал өрсөлдөх чадварын индекс"-ээр 62 дугаарт байрт, Олон Улсын цахилгаан холбооны байгууллага (ITU)-аас гаргадаг кибер аюулгүй байдлын индексээр 120 дугаар байрт тус тус орсон байгаа нь манай улсын хувьд мэдээллийн технологийн дэвшлийг ашиглаж авлигыг бууруулах, эдийн засгийн өсөлтийг дэмжих, төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Төрийн үйлчилгээний нэгдсэн платформ (E-Mongolia) системд төрийн 71 байгууллагын 817 үйлчилгээ, хөдөө орон нутагт 1284 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, "Ухаалаг газрын харилцааны систем (egazar.gov.mn)"-ийг идэвхжүүлэн 156.0 мянга гаруй иргэнд үйлчилгээг хүргүүлсэн. Мөн Улсын бүртгэлийн байгууллагаас 502,933 иргэнд тоон гарын үсгийн гэрчилгээг иргэний үнэмлэхийн чипт суулгаж олгосон байна.

Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банктэй хамтран 2015-2022 оны хооронд хэрэгжүүлсэн "Ухаалаг засаг I төсөл"-ийн хүрээнд харилцаа холбооны дэд бүтэц, инновац үйлдвэрлэл, нээлттэй өгөгдлийг хөгжүүлэн, төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг дараах үр дүнтэйгээр нэмэгдүүллээ. Үүнд:

- Төрийн цахим үйлчилгээний тасралтгүй, аюулгүй байдлыг хангах хүрээнд 12 байгууллагын 112 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, иргэн, хуулийн этгээдээс гарах зардлыг 48.4 тэрбум төгрөгөөр хэмнэж, 11-11 төвд хүлээн авах дуудлагын тоо 3 дахин нэмэгдсэн. Эд хөрөнгийн эрхийн лавлагаа авах хугацаа 3 хоног байсныг 3 минут, гэрчилгээ авах дундаж хугацаа 14 хоног байсныг 3-5 болгон бууруулав.
- Монгол Улсын төрийн цахим мэдээллийн 80 хувийг хадгалдаг "Үндэсний дата төв" /УТҮГ/-ын серверийн өрөөний багтаамж, сүлжээний хүчин чадлыг 2 дахин, өгөгдлийн сангийн багтаамжийг 3 дахин нэмэгдүүлж, төрийн өмчит анхны Нөөц дата төвийг ашиглалтад оруулсан.
- Инновац үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилтын хүрээнд инновац шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гарааны компанийг бойжуулан, 14 нэр төрлийн бүтээгдэхүүн (аппликейшн)-ийг зах зээлд нийлүүлсэн.
- Нээлттэй өгөгдлийн бэлэн байдлын үнэлгээг төрийн байгууллагуудын хэмжээнд үнэлж, 13 байгууллагын 192 өгөгдлийг нэгтгэсэн нээлттэй өгөгдлийн нэгдсэн платформыг 2020 онд ашиглалтад оруулсан.
- Үндэсний статистикийн хорооны мэдээллийн систем, түүний дэд бүтцийг тус тус иж бүрэн шинэчилж, олон улсын "GSBPM" жишигт нийцсэн мэдээллийг цуглуулах, боловсруулах, түгээх цогц системийг нэвтрүүлсэн. Статистикийн мэдээллийн нээлттэй байдлаар Зүүн Азид 1, Дэлхийн 9 дүгээр байранд жагсав.
- Төслийн нийт хугацаанд давхардсан тоогоор 11,818 ажилтан, албан хаагчийг чадавхижуулах сургалт, арга хэмжээнд хамруулж, инновацыг дэмжих

хөтөлбөрийн хүрээнд олон нийт болон оролцогчдод зориулсан сургалтыг 20 удаа 35 чиглүүлэгч багш удирдан 5 үе шаттай зохион байгуулж, 2000 гаруй хүн хамрагдсан.

1.2. Төслийг хэрэгжүүлэх үндэслэл

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 5.3-т "Хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлнэ.", Зорилт 7.5-д "Төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулж, өрсөлдөх чадварыг бий болгоно.", "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.1-д "Цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын Төрийн бүтээмжийн сэргэлтийн 6.1-д "Төрөөс үзүүлэх үйлчилгээг цахимжуулж, төрийн хүнд суртлыг бууруулна." гэж тус тус тусгасан байна.

Дээрх зорилт, арга хэмжээг хангах хүрээнд "Ухаалаг засаг II төсөл"-ийг Дэлхийн банктэй хамтран хэрэгжүүлэхээр тохиролцоод байна. Цахим үйлчилгээний үр ашиг, хэрэглээг сайжруулах, дижитал ур чадварыг дээшлүүлэх, дижитал технологид суурилсан ажлын байрыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд нийт 25 багц арга хэмжээг дараах үндсэн 3 зорилтын хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Нэгдүгээрт, төрийн бүх шатны байгууллага дотроо, өөр хоорондоо, төрийн байгууллагаас иргэн, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагатай цахимаар харилцах систем, орчин нөхцөлийг бүрдүүлэн хэрэгжүүлж, хэвшүүлнэ. Дижитал орчинд ажиллах соёл, арга хэлбэрийг бүрэн хэвшүүлж, эрх зүйн орчныг боловсронгуй болгож төрийн бүх шатны байгууллага дижитал шилжилт хийх үндсэн нөхцөл бүрдүүлнэ.

Хоёрдугаарт, төрийн цахим үйлчилгээний суурь зөөлөн дэд бүтэц болох үндсэн болон дэмжих систем (ХУР, ДАН)-ийг өргөтгөн хөгжүүлж, бүх шатны төрийн байгууллагыг холбох дундын үүлэн шийдлийг нэвтрүүлж, "Үндэсний дата төв"-ийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ. Тоон гарын үсгийн дэд бүтцийг иж бүрэн шинэчилж, тоон гарын үсгийн хэрэглээг дэмжин, төрийн байгууллагын цахим албан бичгийн солилцоог дэмжинэ. Төрийн цахим үйлчилгээний тоо, хэрэглээ, чанарыг нэмэгдүүлнэ.

Гуравдугаарт, Дижитал технологид суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн цахим чадварыг дээшлүүлж, цахим орчинд бизнес эрхлэх боломжийг нэмэгдүүлнэ. Хэрэглэгчдийн тоон бичиг үсгийн мэдлэг, практик түвшний ур чадварыг дээшлүүлнэ. Эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд залуучууд, эмэгтэйчүүдийн оролцоог түлхүү хангана.

2. Төслийн зээлийн хэмжээ, нөхцөл, хамрах хугацаа

Төсөл хэрэгжүүлэгч: Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
Төсөл хэрэгжих хугацаа: 2023 – 2027 он /5 жил/

“Ухаалаг засаг II төсөл”-ийн хүрээнд Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци (ОУХА)-аас олгох 29.5 сая зээлжих тусгай эрхтэй тэнцэх хөнгөлөлттэй зээл нь жилийн тогтмол 2 хувийн хүүтэй, 5 жилийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх нөхцөлтэй бөгөөд зээлийг 30 жилийн хугацаанд төлнө.

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Инновац, цахим бодлогын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хорооны 2022 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаан, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаас өгсөн санал, дүгнэлтийг Зээлийн хэлэлцээрийг соёрхон баталсны дараа үйлдэх төслийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгах боломжтой талаар Дэлхийн банкнаас 2023 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн албан бичгээр мэдэгдээд байна. Үүнд төслийн хэрэгжүүлэгч байгууллагыг Цахим, хөгжил харилцаа холбооны яам болгон өөрчилж, төслийн зөвлөх үйлчилгээний зардалд хуваарилсан 5.4 сая зээлжих тусгай эрхийн хөрөнгийг бууруулан аж ахуй нэгжийн зөвшөөрлийн платформыг дэмжих, аялал жуулчлалын платформд хуваарилах төсвийг нэмэгдүүлэхэд зарцуулах боломжтой талаар дурдсан.

3. Төслийн хүрээнд хийгдэх ажил, хүлээгдэж буй үр дүн

Бүрэлдэхүүн хэсэг	Үр дүн
Бүрэлдэхүүн хэсэг 1: Дижитал шилжилт хийх орчныг бүрдүүлэх	
<ul style="list-style-type: none"> • Дижитал шилжилтийн кибер аюулгүй байдлыг хангах, өндөр хурдны интернэтийн сүлжээг өргөтгөх эрх зүйн орчныг дэмжих. • Дижитал шилжилтийн зохистой хэрэглээг дэмжих өөрчлөлтийн менежментийг нэвтрүүлэх. • Иргэд төртэй цахимаар харилцах, хэлэлцэх, зөвлөлдөх, хамтран ажиллах зорилго бүхий цахим оролцооны системийг нэвтрүүлэх. 	<ul style="list-style-type: none"> • Өгөгдөл хамгаалал, кибер аюулгүй байдал, кибер гэмт хэрэг, цахим шилжүүлэг, цахим худалдааны эрх зүйн орчны олон улсын сайн туршлагыг нэвтрүүлсэн байна. • Өөрчлөлтийн менежментийн хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дижитал дэд бүтэц ашиглан дижитал үйлчилгээг хүргэх дижитал орчны төрийн албан хаагчид болж төлөвшсөн байна.
Бүрэлдэхүүн хэсэг 2: Дижитал шилжилтийн дэд бүтцийг сайжруулах	
<ul style="list-style-type: none"> • 100 ба түүнээс дээш тооны үйлчилгээг цахимжуулах, цахим үйлчилгээний хэрэглэхэд хялбар шалгуур үзүүлэлтийг сайжруулах, нэмэгдүүлэх. • Ил тод байдлыг хангах, авлигыг бууруулах зорилго бүхий системүүдийг хөгжүүлж, шинэчилж, нэвтрүүлэх. (худалдан авах ажиллагааны цахим портал, тусгай зөвшөөрлийн нэгдсэн систем, хөрөнгө, орлогын мэдүүлгийн системийн 2-р үе шат) • Үндэсний аялал жуулчлалын порталыг хөгжүүлэх, “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн цахимжуулах, • Засгийн газрын шийдвэрийн цахим мэдээллийн сан үүсгэх, лавлагаа өгөх үйл ажиллагааг цахимжуулах, • Үндэсний дата төвийг үндэсний клауд буюу үүлэн тооцооллын платформ (ҮТП) болгон шинэчлэх, 	<ul style="list-style-type: none"> • Шинээр цахимжуулсан 100 үйлчилгээний хэрэглэхэд хялбар байдлын шалгуур үзүүлэлт сайжирсан байна. • Үндэсний дата төв, түүний нөөц төвийн хүчин чадал шинэчлэгдэж, шинэ технологийг нэвтрүүлж, уян хатан, эрчим хүчний хэмнэлттэй болсон байна. • Монгол Улсын нийтийн түлхүүрийн дэд бүтцийг (PKI) шинэчилснээр төрийн нийт албан хаагчдын тоон гарын үсэг ашиглалт нэмэгдсэн байна. • Үндэсний хэмжээний кибер аюулгүй ажиллагааны үйл ажиллагаа жигдэрсэн байна. • Төрийн клауд платформыг хамтран ашигласнаар 12 сая ам.долларын хэмнэлт бий болсон байна. • Төрийн цахим үйлчилгээний тоо нэмэгдэж “E-Mongolia” цахим системээр дамжуулан

<ul style="list-style-type: none"> • E-Mongolia системийг дэмжих системүүдийг нэмэгдүүлэх, • Тоон гарын үсгийн дэд бүтцийг өргөтгөх. 	<p>24/7 горимоор иргэдэд хүргэнэ.</p> <ul style="list-style-type: none"> • Улсын бүртгэлийн цахим мэдээллийн хадгалалт хамгаалалт, нууцлал аюулгүй байдлыг сайжруулах дэд бүтцийг бий болгоно.
Бүрэлдэхүүн хэсэг 3: Дижитал эдийн засгийг хөгжүүлэх хүний нөөцийг бэлтгэх, чадавхижуулах	
<ul style="list-style-type: none"> • Төрийн албаны дижитал ур чадварыг нэмэгдүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх, төрийн албаны онлайн сургалтын системийн цахим контентыг нэмэгдүүлэх. • Дижитал технологийн хэрэглээний хоцрогдол бүхий зорилтот бүлэгт зориулсан дижитал ур чадварыг нэмэгдүүлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх. • Залуусын мэдээллийн технологийн боловсролыг дээшлүүлэх замаар орон нутгийн дижитал зах зээлд ажиллах эсхүл жижиг, дунд бизнес эрхлэх дижитал ур чадвар олгох хөтөлбөрийг хэрэгжүүлэх. • Мэдээлэл, харилцаа холбооны мэргэжилтнээр суралцсан залуусын дотоод болон олон улсын хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх МХХТ-ийн гүнзгийрүүлсэн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх. 	<ul style="list-style-type: none"> • 3000 төрийн албан хаагчид дижитал технологи, загварчлалын чиглэлийн ахисан түвшний ойлголт, өрсөлдөх чадвар, хэрэглээнд ашиглах дадал олгох сургалтад хамрагдсан байна. • 10,000 иргэнд тоон бичиг үсгийн боловсрол олгох сургалт /50% эмэгтэй/. • 3000 залууст зориулсан дижитал суурьтай ажлын байрыг бий болгоно /50% эмэгтэй/ • 2000 жижиг дунд бизнес эрхлэгчид дижитал шийдлийг бизнестээ нэвтрүүлсэн байна. • Төслийн хүрээнд дижитал ур чадварын чадавхи 30% сайжирсан байна. • Дижитал технологид суурилсан ажлын байр 3000, үүнээс 50% эмэгтэй. • Дижитал шийдлийг нэвтрүүлэх жижиг, дунд бизнесийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжүүлсэн байна.

4. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлтэй нийцсэн байдал

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.3-т заасны дагуу Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийн ДНБ-д харьцуулсан харьцаа нь 2022 онд 70 хувь, 2023 онд 65 хувь, 2024 оноос эхлэн 60 хувиас хэтрэхгүй байхаар тус тус хуульчлагдсан.

Энэ хүрээнд 2022-2025 оны хооронд эдийн засгийг харгалзан 4.0 хувь, 4.5 хувь, 5.1 хувь, 6.1 хувиар өсч, Монгол Улсын 2022 оны батлагдсан төсөв, 2023 оны төсвийн төсөл, 2024-2025 оны төсвийн төсөөлөлд тусгагдсан гадаад зээлийн хөрөнгийг авч ашиглах тохиолдолд өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь 2022 онд 56.6 хувь, 2023 онд 53.2 хувь, 2024 онд 51.7 хувьтай тус тус тэнцэхээр тооцоологдсон. Ингэснээр эдгээр онд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлагыг хангахаар байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР